

“ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ БА НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛ” НОМЫН ТУХАЙ

*Ч.Батцэцэг**

2004 онд Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны академийн эрдэмтэн судлаач Оронч, Оч, Сунь Сюели нарын олон эрдэмтэн “Тогтолцооны өөрчлөлт ба нүүдлийн соёл иргэншил” хамтын бүтээлийг бичиж Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороонд хэвлүүлсэн нь эрдэм шинжилгээний шилдэг бүтээлээр шалгарсан байна.

Хамтын бүтээл: Оршил, 1. “Мал аж ахуй эрхэлдэг нутгийн эдийн засгийн тогтолцооны хувьсал болон өөрчлөлт”, 2. “Тал хээрийн бүсийн байгаль-экологи болон мал аж ахуй эрхэлдэг нутгийн эдийн засгийн бүтэц”, 3. “Нүүдлийн мал аж ахуйн соёл иргэншил ба байгаль экологийн соёл иргэншил”, 4. “Хятад, Монголын тал хээрийн бүс нутгийн мал аж ахуйн харьцуулсан судалгаа” гэсэн 4 бүлэгтэй, 25 зүйл, 502 хуудас буюу 380 мянган ханз үсгээс бүрджээ.

“Тогтолцооны өөрчлөлт ба нүүдлийн соёл иргэншил” ном нь мал аж ахуй эрхэлдэг тал хээрийн бүсийн байгалийн онцлог, эдийн засаг, соёлын талаар тухайн газарт нь судалгаа явуулан, олон өнцөгөөс харж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бичсэн эрдэм шинжилгээ-судалгааны бүтээл юм. Номын агуулгын үндсэн онол нь бүхэлдээ тал хээрийн бүсийн мал аж ахуй эрхэлдэг нутгийг “тасралтгүй тууштай хөгжүүлж болно” гэсэн үзэл санааг нэвт шингээжээ.

Тал хээрийн бүсийн мал аж ахуй эрхэлдэг нутгийг бодитоор хэрхэн тасралтгүй тууштай хөгжүүлэх вэ? Үүний тулд судлаачид юуны өмнө эдийн засгийн тогтолцооноос эхлэн судалгаа хийж, экологийн тогтолцооны онолын тэнцвэргүй байдал болон экологийн соёл иргэншлийн үзлээс дахин шинэ ойлголт авах, мал аж ахуйтай тал нутгийн байгаль, эдийн засаг, соёлын тогтолцоог үнэлэх хэрэгтэй гэдгийг баталсан байна. Тогтолцоонд эдийн засгийн ухааны задлан шинжлэх аргаар судалгаа хийснээр, мал аж ахуй эрхэлдэг тал хээр нутгийн үл хөдлөх хөрөнгийн тогтолцоо (өмчийн тогтолцоо), зохион байгуулалтын тогтолцоо, удирдлага менежментийн тогтолцоо, тэдгээрийн бодлогыг дээд зэргээр боловсронгуй болгон хэрэгжүүлэх; экологийн тогтолцооны тэнцвэргүй байдлын онолд судалгаа хийж, хойд зүгийн ган гачиг ихтэй тал хээрийн бүсийн экологийн тогтолцооны онцлогтой эд өлгийг хөдөлгөх дүрэм журам болон түүнийг хөрвүүлэх, тэнцвэржүүлэх, хөрвөх чадвартай болгох; нүүдлийн мал аж ахуйн бэлчээрийн асар том соёл иргэншилд байгаль экологийн соёл иргэншил хамгийн чухал хэсэг мөн бөгөөд улмаар монгол үндэстний соёл, уламжлалын давуу тал нь газар

* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

нутаг, байгалаа хамгаалах соёл иргэншлийн үзэл мөн гэдгийг тодорхойлон гаргахыг зорьжээ.

Эрдэмтэд хамтын бүтээлдээ мал аж ахуйтай тал хээрийн бүс нутгийн түүх, хувьслын нөхцөл байдал, байгаль, эдийн засаг, тогтолцоо хийгээд үзэл баримтлалыг тус бүр хүчин зүйл, бүтцийнх нь хамт системтэй авч үзсэн байна. Эдгээр системийн харилцан нөлөөлөл, харилцан өөрчлөгдөх нөхцөл, байгаль, эдийн засаг, соёл салгахын аргагүй нэг бүтэцтэй амьд бие юм гэж тодорхойлоод номоо бүтэц, нөхцөл байдал гэсэн хоёр онцлогтой бичжээ. Үүнд: нэгд, малын өвс тэжээлийн нөөцөөс, эдийн засгийн бодлогын тогтолцооны үнэ өртгийн хэлбэрт хүрэх; хоёрт, түүхэн хөгжил, хувьслаас задлан шинжилгээ, үнэлэлт дүгнэлтэнд хүрэх, бодлого буюу хөгжлийн санаа дэвшүүлэхэд оршиж байна хэмээн оршил хэсэгтээ бичсэн байна.

Хамтын бүтээлд эрдэмтэн судлаачид дараах 6 зүйлийн асуудлыг чухалчлан авч үзжээ. Нэгдүгээрт “Тогтолцооны өөрчлөлтийн соёл учир шалтгаан”-ыг эрдэмтэд маш дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн байна. Тухайлбал, “тогтолцоо” (“zhi du”) хэмээх үг маш олон газар дайралдана, ялангуяа үл хөдлөх хөрөнгийн тогтолцоо, үйлдвэрлэл техникийн талын тогтолцооны төсөлд тодорхой заасан байгаа гээд, нүүдлийн мал аж ахуйн тогтолцоо, хуваарьт газар малаа ээлжлэн хариулах тогтолцоо, малын хашаа, тэжээлийн тогтолцоо г.м. жишээ татжээ.

Тогтолцооны өөрчлөлт болон тогтолцооны хувьсал нь ялангуяа мал аж ахуй эрхэлдэг бүс нутгийг тасралтгүй хөгжүүлэхэд маш хэрэгтэй, чухал үзэл санаа юмаа. Ийм тогтолцоог нэг өдөр ч байгуулж болно, гэвч тогтвортой, тасралтгүй үргэлжлэх шинжтэй байх ёстой. Тогтолцоо түргэн өөрчлөгдвөл, хүмүүс хувийнхаа ашиг сонирхолд нийцүүлэн хууль бусаар төсөл, дүрэм журам тогтоон, үйл ажиллагаа явуулахад хүрч, улмаар үр ашиг муутай, байж боломгүй шинж үүсэх нь гарцаагүй. Тогтолцоо тогтвортой байвал бас л тогтонгшиж нийгмийн дэвшилд саад болох нь мэдээж. Тогтолцоог түргэн буюу удаан өөрчлөх нь зөвхөн хэлбэрийн асуудал юм. Тогтолцоог өөрчлөхдөө мэдээжийн хэрэг төгс боловсронгуй тогтолцоог сонгож авах бөгөөд юуны өмнө хүмүүс тогтолцоог халахдаа шинэ тогтолцооны арга хэлбэрийг сонгох нь зайлшгүй. Тогтолцооны өөрчлөлт, тогтолцооны сонголт нь үндсэндээ нягт харилцан уялдаатай байдаг.

Мал аж ахуй эрхэлдэг бүс нутгийн эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт ер нь ямар байх вэ? Өнөөгийн тал хээрийн бүсийн мал аж ахуй нь хэдэн мянган жилийн турш явж ирсэн нүүдлийн мал аж ахуй аажмаар хувьсан сайжирсан үйл явц юм. Нүүдлийн мал аж ахуйн тогтолцооны хамгийн том шинж чанар нь гадаад орчны аливаа өөрчлөлтөд гайхалтай зохицож, оршин тогтнох төгс байдалд хүрчээ.

Гэвч өнөөдөр богино хугацаанд тариалангийн соёл нөлөөлж, мал аж ахуйтай нутагт үр тариа маш их тариалснаар газар тариалангийн үйлдвэрлэлийн хэв загвар, дүрэм журам бүхий талаар нэвтэрч, мал аж ахуйтай нутгийн үйлдвэрлэлийн арга ажиллагаа, тогтолцооны хэв загварыг төлөөлөх болж, тал хээрийн бүс нутаг маш түргэн элсжин цөлжиж, нүүдлийн мал аж ахуйн соёл түргэн устаж, үгүй болж байна.

Хятадын үйлдвэрлэлийн уламжлалт үндсэн арга нь газар тариалангийн соёл юм. Газар тариалангийн соёлын хамгийн том шинж чанар бол тогтмол бүтэцтэй, тогтсон хил хязгаартай, байгалийн нөхцөл байдлын өөрчлөлт харьцангуй бага, ирээдүйг урьдчилан таамаглах боломжтой байдаг. Харин нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хамгийн том шинж чанар нь байгалийн байдал тогтворгүй, хил хязгаар тодорхой бус, нөхцөл байдлын өөрчлөлт харьцангуй ихтэй, хэтийг урьдчилан таамаглах аргагүй байдагт оршино. Газар тариалангийн соёл болон нүүдлийн мал аж ахуйн соёл нийлээд газар тариалан, мал аж ахуй хосолсон бүс нутаг байх нь мэдээжийн хэрэг юмаа гэсэн дүгнэлтийг судлаачид хийгээд иймээс энэхүү тогтолцоог хэрхэн өөрчлөх тухай үзэл бодол, санал сэтгэгдлээ тодорхой тусгасан байна.

Хоёрдугаарт “Нүүдлийн мал сүргээ ээлжлэн хариулах тогтолцоо хийгээд тал хээрийн бүсийн үл хөдлөх хөрөнгийн эрх”-ийн талаар нэлээд нухацтай авч үзжээ.

Мал аж ахуй эрхэлдэг тал нутгийн эдийн засгийн гол үндэс нь нүүдлийн мал аж ахуй юм. Мал маллах аж ахуй нь нүүдлийн мал аж ахуйгаас шалгаран уламжилж ирсэн оновчтой боловсронгуй арга хэлбэр болохын сацуу орчин үед шинжлэх ухаан, техник, үйлдвэрлийн удирдлагын тухайд сайжирч байгаа хэдий ч монгол үндэстний хувьд, тал хээрийн бүс нутгийн мал аж ахуй нь зөвхөн эдийн засгийн суурь оршин тогтнох болон түүний хөгжлийн эд өлгий бус, чухамхүү үндэстний соёл, оюун санааны ертөнцийг үүсгэгч, хөгжлийн өлгий юм; тал хээр нутгийн мал аж ахуй зөвхөн малын гаралтай үйлдвэрлэлийн олон төрлийн бүтээгдэхүүн, байгалийн бохирдолгүй цэвэр бүтээгдэхүүн мах, сүүг хүн ардад нийлүүлээд зогсохгүй, мөн Хятадын хойд зүгийн экологийг хамгаалах чухал хүнд хариуцлагыг үүрч байна. Иймээс бидэнд түүх, шинжлэх ухаан болон бүхий л талаар тэр ч байтугай дэлхийн экологийн байдал, соёлын дээд төвшний олон янзын хэв шинжээс суралцаж, тал хээр нутгийнхаа мал аж ахуйг дахин шинээр нягтлан, үнэлэлт дүгнэлт өгөх хэрэгтэй болж байна.

Тал хээрийн бүс нутгийн үл хөдлөх хөрөнгийн үр ашигтай загвар нь бодит байдалд мал аж ахуйтай нутгийн хөгжлийн тогтолцооны баталгаа байж болох ... гээд Өвөр Монголын эрдэмтэн судлаачид энэ бүлэгт түүхийн урт хугацаанд явж ирсэн тогтолцооны дотоод, гадаад

шинж байдлыг авч үзэн, эцэст нь харилцан үйлчилж, хувьсахад бүрэлдэн тогтсон үйл явц гэж тодорхойлжээ.

Орчин үеийн нийгэм эдийн засгийн төвөгтэй байдал нь ялангуяа хөдөлмөрийн хуваарийг улам нарийсгаж, гадаад тогтолцоон дахь нийтийн нөөц баялгийг удирдан явуулах журам буюу эсвэл гаднаа эдийн засгийн бус нэр хүнд, үр ашиг, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэх мэт шинжээс бүрдэж байна. Ялангуяа эдийн засгийн дээрхи үзэл түгэн дэлгэрч, улмаар нөлөөлж, олон янзын арга хэлбэрээр довтлон, тал нутгийн нөөц баялагтай холбоотой үйл ажиллагааг эвдэн бусниулж байгаатай холбогдуулан гадаад тогтолцооны хатуу чанд журам тогтоон хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Тал хээрийн бүс нутгийн үл хөдлөх хөрөнгийн дотоод тогтолцооны үндсэн байдал - нүүдлийн мал аж ахуйн зарчим нь эртний монголчууд бүр дээр үеэс л мал аж ахуйн үйлдвэрлэлд аажмаар хувьсан өөрчлөгдсөн явдал юм. Малчид урт хугацаанд шалгарч ирсэн арвин туршлагатай, бэлчээр сэлгэж ашиглах мэдлэгтэй, тухайн бэлчээрийг гэмтэл сүйтгэлээс хамгаалж чаддаг байсан учраас асар том бэлчээрийг тасралтгүй ашиглаж иржээ. Энэ нь аажмаар нүүдлийн мал аж ахуйн дүрэм болсноор, малчид өөрсдөө сахин мөрдөх дүрмийн тогтолцоо болжээ. Нүүдлийн мал аж ахуйн дүрэм нэг талаас монголчуудын “таван хошуу мал” (адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа) болон дээр нь тал хээрийн бүсийн экологийн газрын гадаргуу, өвс ургамлын зохирол харилцан бие биенээ нөхөн гарч ирсэн, нөгөө талаас малчдын хооронд бэлчээрийг нийтээрээ ашиглах буюу бэлчээрийг ашиглахдаа ардууд өөрсдийн журам, зан үйлээ солилцдог онцлогтой байлаа.

Хэдэн мянган жилийн турш, малчид тал хээрийн байгаль экологийн тэнцвэргүй байдлын тухайд мэдлэгтэй байж, байгаль экологи хийгээд нүүдлийн мал сүргээ хариулахад тохирсон дүрмийг (дөрвөн улиралд ээлжлэн хариулах, оторлох г.м багтана) зохион гаргажээ. Бүтэн жилийн турш малаа хариулахдаа дөрвөн улиралдаа зохицуулах, малын бэлчээрийг улиралдаа тохируулан хуваан ашиглах үндэслэлийг бий болгосон юм. Бэлчээрийг улиралдаа тохируулах нь газрын гадаргуу, усны ундарга, өвс ургамлын байдал зэрэг хүчин зүйлээс шийдэгдэнэ.

Мал аж ахуйн уламжлалт тогтолцооны мөн чанар нь нүүдлийн мал сүргээ ээлжлэн хариулах тогтолцоо юм. Малаа ээлжлэн хариулахдаа юуны өмнө өвсний соргог, усны цэнгэгийг ашигладаг давуу талтай, “байгаль экологийн тогтолцооны тэнцвэргүй нөхцөлд” хураан нөөцөлсөн өвс тэжээлээ хэрэглэж, дараа нь хэдэн мянган жилийн туршид хэрэглэх тал хээр нутгийнхаа үржил шимтэй байгаль экологийн тэнцвэртэй тогтолцоог хадгалж ирсэн билээ. Уламжлалт мал хариулгын дотоод тогтолцоонд (соёл, ёс заншил, ёс суртахуун г.м), гадаад тогтолцоонд (үл хөдлөх хөрөнгө, хууль дүрэм г.м) байх агаад харилцан үйлчилж, хамтдаа

хувьсан өөрчлөгдөж, тал хээр нутгийнхаа байгаль экологи, эдийн засаг, соёлтой ашигтайгаар зохицдог учраас тасралтгүй хөгжиж болно.

Уг номын нэг чухал санаа бол мал хариулах хариуцлагын тогтолцоонд шинжлэх ухааны үр ашигтай тогтолцооны үндсэн хүчин зүйлийг шингээж, уламжлалт тогтолцоонд үл хөдлөх хөрөнгийн бүрхэг байдал, үр дүн муутай үйл ажиллагааг хэрэгсэхгүй болгож, орчин үеийн шинжлэх ухаан техник болон хувийн үл хөдлөх хөрөнгийн тогтолцоог цогцоор нь тодруулах, үр ашигтай байх боломж зэрэг чухал хүчин зүйлийг бий болгох явдал юм.

Улмаар Өвөр Монголын судлаачид үл хөдлөх хөрөнгийг яв цав тодорхойлсон нөхцөлд, газар орны харилцан адилгүй байдалд, өнөөгийн нүүдлийн мал сүргийг ээлжлэн хариулах арга хэлбэрийг хошуу, гацаа, хот айл, малчин өрхийн жишээгээр улирал улиралд хэрхэн нэгдэж ажиллахыг 6 зүйлд хуваан гаргасан байна. Тэгээд тал хээр нутагт өмчийн тогтолцоог бий болгож, бүх талаар ардчилсан үйл ажиллагаа явуулж, хууль зүйн хэв журамд оруулах хэрэгтэй байна гэсэн санал дэвшүүлжээ. Зөвхөн ардчилсан бодлого шийдвэр, хууль зүйн хэв журмыг нухацтай болгосноор сая байгаль экологи хийгээд эдийн засаг, цөөн хүн болон олон хүний хоорондын эдийн засаг, цөөн тоот үндэстний эдийн засаг болоод соёл уламжлал үр ашигтай байна, ойрын болон урт хугацааны үр ашиг гарч байж, тал нутгийн эрхийн тогтолцооны хүчин зүйлийг дагаж мөрдөх болно, тэр цагт л сая бүр дээрээс хамгийн доод төвшин хүртэлх тогтолцоог өөрчилж, хүнд дарамтаас гарч чадна гэсэн дүгнэлтийг эрдэмтэд хийжээ.

Гуравдугаарт, “Эдийн засгаа хамтран сэргээн босгоё” гэсэн санааг гол үндэс болгожээ. Монгол үндэстэн эрт дээр үеэс нүүдлийн мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтанд орсны дараа мал сүргээ түргэн өнтэй өсгөх, хөдөлмөрийн хуваарийг нарийвчилж (жишээ нь: адуучин, үхэрчин, хоньчин, гм), нүүдлийн мал сүргээ өсгөж маллахын дээр нэг бус удаа дайрах байгалийн бэрхшээлийг тооцоолон нүүдэлчин малчин ардын хоорондын холбоо, хамтын хөдөлмөр хуваарилалтыг маш өндөр шаардлагатай гаргаж иржээ. Зөвхөн малчин өрхийн холбоо, хөдөлмөрийн хуваарилалт, харилцан бие биедээ туслах гэх зэрэг маш олон төрлийн чухал ажил бүрэлдэн тогтож байж, сая мал сүргээ байгалийн бэрхшээлээс авран хамгаалж чадна.

Эдийн засгийн тогтолцоогоо хамтын хүчээр сэргээн босгож, тал хээр нутгийнхаа нөөцийг үр ашигтай байрлуулж, хөдөлгөөнд оруулж, зах зээлийн өрсөлдөөний байр суурийг дээшлүүлэхийн тулд малчдыг өөрсдийг нь үйл ажиллагаанд татан оруулж, харилцан туслах, ардчилал, тэгш эрх, шударга ёс, эв нэгдлийг дээдлэх хэрэгтэй байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн зохион байгуулалттай хамтын ажиллагаа зайлшгүй чухал бөгөөд хамтын ажиллагааны янз бүрийн, олон хэлбэрийн

арга барил болон хамтын ажиллагааны бүтцийг шинээр тандан судалж, тогтолцооны өөрчлөлт болоод тогтолцоог шинээр байгуулах үр ашигтай оновчтой үйл ажиллагаа чухал байна хэмээн эрдэмтэд бичжээ.

Өнөөгийн Өвөр Монголын тал хээр нутгийн мал аж ахуйн үйлдвэрлэл зохион байгуулалтыг удирдан явуулах загвар нь өрхийн аж ахуйн гол суурь болж байна. Цаашид тухайн нутгийн нөхцөл байдлыг зайлшгүй харгалзан малын тоо толгойг хүн нэг бүрт тэнцүү эзэмшүүлэх, оршин суугчдын ахуй байдал, байршлыг үндэслэж, чухалчилан хөгжүүлэх хоёр төрлийн загварыг санал дэвшүүлсэн байна. Үүнд: нэгд. өрхийн бэлчээрийн үйлдвэрлэлийн дүрэм журам байх ёстой, хоёрт, эдийн засгийн холбооны зохион байгуулалтыг үйлдвэрийн харьцангуй өндөр дүрэм журмаар бэлтгэх, тэр нь тодорхой арга хэлбэрт, тодорхой нөхцөлтэй байж болно.

Өрхийн холбоо буюу эдийн засгийн удирдлагын хамтын арга ажиллагаа л гэхэд өнөөдөр маш олон янзын хэлбэртэй байж үндсэндээ гурван зүйл дээр нэгдэж иржээ. Нэгдүгээрт, зун, намартаа малаа нийлж хариулан бэлчээрээ ашиглаж байна. Хоёрдугаарт, зун намартаа малаа нийлж хариулах, бэлчээрээ ашиглахаас гадна малчин өрх сайн дураараа зохион байгуулж, өвөл, хаварт нөөцөлж хураасан өвс тэжээлээ солилцон хэрэглэж байна. Гуравдугаарт, эдийн засгийн хамтын ажиллагаа буюу эдийн засгийн хувьцаа эзэмших талаар харьцангуй хатуу чанд байгаа. Ийм маягаар өнөөдөр харьцангуй бага, дөнгөж эхлэл төдий байгаа мэт боловч цаагуураа зах зээлийн өрсөлдөөний чадавхийг сурталчлан, хөхүүлэн дэмжих явдал маш ихээр хөгжиж хүчээ авч байна.

Хоршиж ажиллахад “хувь хүний үзэл” бодол санааг эрхэмлэн дээдэлдэг. Хоршиж ажиллах үзэл баримтлалын гол үнэлгээ нь хувь хүний нийлүүлсэн хөдөлмөрийн хувьцаа болно; хоршигчид өөртөө болон харилцан бие биедээ туслах, ардчилал, тэгш эрх, шударга ёс, эв нэгдлийг онцолно; хоршоололд шударга, нээлттэй, нийгмийн хариуцлагын мэдрэмж, түүнд оролцогчийн ёс суртахууны зарчмыг анхаардаг.

Хамтын бүтээлд оролцсон эрдэмтэд өнөөдөр бид “тасралтгүй тууштай хөгжиж болно” гэсэн үзэл баримтлалыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дэвшүүлж байна. Хүн төрөлхтөн сайн сайхан, үнэн бодитоор цэцэглэн хөгжих, тэгш эрх зохицон нийлсэн нийгмийг хөгжүүлэх загварыг бүхий л хүчээрээ байгуулахын тулд бидэнд мэдлэгийн онолын үндэс суурь болох түүх, бодит байдал, байгалийн хууль, эдийн засгийн хууль нийгэм, соёлын хөгжил, хувьслын хууль г.м бүх талын мэдлэгийг шаардаж байна гэжээ.

Дөрөвдүгээрт “Тал хээр нутгийн мал аж ахуйд тулгамдаж байгаа асуудал ба авч буй арга хэмжээ”-ний талаар нэлээд дэлгэрэнгүй бичжээ.

Хятадын хойд зүгийн мал аж ахуй эрхэлдэг тал хээрийн бүс дэлхийд хуурай газрыг эзэлж, хагас хуурай газраар хүрээлэгдсэн

байгаль экологийн давтагдашгүй онцлог тогтолцоотой. Хэдэн мянган жилийн турш энд газар тариалангийн ажлыг эрхэлж байсангүй, учир нь цаг агаар, усны нөөц, хөрсний бүтэц, ургамлын тархалт болон холбогдох байгалийн хүчин зүйлүүдээс шалтгаалан газар тариалан дорвитой хөгжиж чадаагүй. Цаг агаарын хувьд хуурай, хүйтэн, усны нөөцөөр хомс, хөрс элсжиж, мал идээших ердийн талбайн өвсний хэмжээ маш бага, ашиг шим нь өөрчлөгдсөн харьцангуй уудам тал хээр нутагтай, зөвхөн нутаг сэлгэн гэр малаа нүүлгэж, нүүдлийн мал аж ахуйгаа эрхэлж өвсний нөөцтэй газрыг сайтар ашиглаж байж сая эдийн засгийн тогтвортой ашиг шимийг хүртэж иржээ.

Тал нутгийг тасралтгүй тууштай хөгжүүлэхдээ тал хээрийн бүсийн байгаль экологийн үндсэн шинж чанарыг ойлгох болон авч ашиглах гэсэн хоёр ухагдахууныг салгаж болохгүй юмаа. Өвөр Монголын тал хээр нутгийн байгаль экологийн онцлог болон түүний хууль дараах чухал 3 зүйлээр илэрнэ. Үүнд: нэгд, хэврэг; хоёрт, тэнцвэргүй; гуравт, байгалийн гамшигт өртөмтгий шинжтэй байдаг.

Хорьдугаар зууны эхээр, Өвөр Монголын мал сүргийн өсөлтийн хэмжээ ойролцоогоор 70 сая хонь, дээр нь зэрлэг хонийг (зээрийг оруулсан бололтой-Ч.Б) нэмээд нийт 80 сая хоньтой байв. Хорьдугаар зууны 30-аад оноос хойш, японы түрэмгийлэгчдийн дайн болон дотоодын үймээн самууны үеэр Өвөр Монголын мал аж ахуй зогсонги байсан. Чөлөөлөлтийн эхэн үед, мал сүргийн өсөлтийн хэмжээ буурч 2600 хоньтой (1950 онд 26 сая хоньтой байв) 1950-1965 оны хооронд 15 жилийн дотор Өвөр Монголын мал аж ахуйн үйлдвэрлэл маш түргэн хөгжиж, малын нийт тоо толгой ойролцоогоор 70 сая (1965 онд 69 сая) болж, 2.65 дахин өсчээ. 1965-2000 он хүртэл 35 жилийн хооронд малын нийт тоо толгой 70 сая орчимд хэлбэлзэж байв.

Байгалийн бэлчээрт малаа хариулахын гол утга учир нь тал нутгийн мал аж ахуй, түүний малын бүтэц болон малын байршилд тал хээр нутгийн байгаль экологийн системийн төрөл, нөхцөл чухал байдагт оршино. Өвөр Монголын мал аж ахуйтай нутгийн малын төрөл, нөхцөл байдал болон тал нутгийн байгалийн онцлог адил байдаг. Тухайлбал: зүүн болон төвийн хэсэгт бэлчээрийн нөхцөл харьцангуй сайн, үхэр, адуу, хонь зэрэгт өгөг байдаг бол баруун хэсгийн бэлчээрийн нөхцөл харьцангуй ялгаатай, байгалийн байдал ширүүн, ямаа, тэмээ гэх мэтийн малд өгөөжтэй байдаг ажээ.

Өвөр Монголын эрдэмтэн судлаачид, өнөөдөр мал аж ахуй эрхэлдэг нутаг үйлдвэржин маш түргэн хөгжиж, ялангуяа зарим нэг үйлдвэрийн газрууд маш их бохирдол дагуулж байгаа нь тал нутгийг шинээр сүйтгээд зогсохгүй өргөжин тэлэх хандлагатай байна гэдгийг онцлон тэмдэглэж, үйлдвэрийн бохирдол болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар дүн шинжилгээ хийжээ.

Тавдугаарт. “Нүүдлийн мал аж ахуйн байгалийн соёл иргэншил нь тасралтгүй хөгжиж болох дэвшилтэт үзэл баримтлал мөн” гэдэг саналыг дэвшүүлжээ.

Нүүдлийн соёл иргэншил нь дэлхийн соёл иргэншлийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүн төрөлхтөний соёл иргэншлийн өв юмаа. Археологийн олдворын судалгаанаас үзэхэд, нүүдлийн соёл иргэншил болон байгалийн онцлог маш эртнээс зохицон оршиж ирсэн нь хүн төрөлхтөний соёл иргэншлийн асар баялаг өв сан болж байна. Өнөөдөр хүн, байгаль зохицон орших үзэл баримтлал, нүүдлийн соёл иргэншил, соёлын тухайд олон улсын эрдэмтэн судлаачид өөр өөр байр суурьтай, олон ургальч үзэл санаатай, өөр өөрийн үзэл бодолтой болжээ.

Өвөр Монголын нутаг бол тал хээрийн бүсийн нүүдлийн соёл иргэншлийн өлгий, өвөг дээдсээс заяасан нутгийн нэг юмаа. Гэвч түүхийн явцад энэхүү соёл иргэншил сүүлийн үед гэнэтийн дайралтанд өртөж, нүүдлийн малаа бэлчээх газар илт багасаж, нүүдлийн мал аж ахуйн арга улиран өөрчлөгдөж байгаа хэдүй ч монгол үндэстний зүрх сэтгэлд маш олон зүйл урьдын хэвээр хадгалагдан, өв уламжлагдаж ирсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн байна. Тухайлбал: эрдэмтэн судлаачид хэл бичиг, утга зохиол, соёл урлаг, түүх, эдийн засаг, нөөц баялаг, байгаль орчин зэрэг шинжлэх ухааны өөр өөр салбараас соёл иргэншлийн судалгааг урт хугацаанд явуулж иржээ.

Өвөр Монголын өнөөгийн бодит байдлаас харахад, нүүдлийн соёл иргэншлийг бүхий талаас нь, мөн түүнчлэн тогтолцооны асуудлаар хийж буй судалгаа нь цаашид мал аж ахуй эрхэлдэг нутгаа тууштай хөгжүүлэхэд түлхэц болох, асар удам бэлчээр, монгол үндэстний соёл, уламжлалын давуу байдалд тус дэм болох үүднээс гүнзгийрч байгаа ажээ.

Нүүдлийн соёл иргэншил хийгээд мал аж ахуй эрхэлдэг нутгаа хөгжүүлэх талаар явуулж буй судалгааны бодит үзэл санаа нь Өвөр Монголын өөртөө засах орны эдийн засаг, соёлын хөгжлийн онцлогт тохируулсан бодлого боловсруулах, шинжлэх ухааны үндэслэлтэй иж бүрэн цогц тогтолцоог дэвшүүлэхэд оршиж байна.

Нүүдлийн соёл иргэншлийн гол цөм нь байгаль экологийн соёл иргэншил юмаа. Орчин үеийн соёл иргэншлийн тухайд, нүүдлийн соёл иргэншлийн гол цөмийн үнэлгээний тогтолцоо нь байгаль экологийн соёл иргэншил мөн. Байгаль экологийн соёл иргэншил нь хүн төрөлхтөний соёл иргэншлийн эх үүсвэрийн үндэс, бас хүн төрөлхтөний соёл иргэншлийн үр дагавар гэж хэлж болно. Энэ бүлгийг дээрхи утга санааг илэрхийлсэн олон эрдэмтэн судлаачийн бичсэн бүтээлээс ишлэл татаж, дэвшүүлсэн санал, баримталж буй онолын асуудлаар бичжээ.

“Хятад, Монголын тал хээр нутгийн мал аж ахуйг харьцуулсан судалгаа” хэмээх 4-р бүлэгт “БНХАУ, Монгол Улсын мал аж ахуй эрхэлдэг

нутгийнхан бие биеийнхээ алдааг давтах ёсгүй” гэдэг санааг гол үндэс болгоод Өвөр Монголын болон Монгол Улсын аймаг, сумын малын тоо толгойн өсөлтийг харьцуулан судалж хүснэгтээр үзүүлсэн байна.

БНХАУ, Монгол Улс нь сайн хөршийн найрсаг харилцаатай, хоёр улс бүр эртнээс нүүдлийн мал аж ахуйн эдийн засгийн уламжлалын түүхтэй, байгаль экологийн нөхцөл байдал нь тал хээрийн бүсэд мал аж ахуй эрхлэхэд маш тохиромжтой. Байгалийн нөхцөл байдал болон түүхийн талаар адил төстэйгээс гадна сүүлийн үед хоёр улсын тал нутгийн мал аж ахуйн салбарт харилцан суралцах, харилцан алдаагаа давтахгүй байх хамтын ажиллагаа өргөжин, нээлттэй болж байна.

Хятад, Монгол хоёр улсын мал аж ахуй эрхэлдэг нутагт тогтолцооны уламжлал болон түүнийг шинээр бий болгох асуудал адил тулгарч байгаа юмаа. Жишээ нь: малаа бэлчээх тогтолцооны асуудал гэхэд тал хээрийн бүс нутгийн үл хөдлөх хөрөнгийн асуудал, мөн түүнчлэн мал аж ахуй эрхэлдэг нутгийн эдийн засгийг зохион байгуулах асуудал нь хоёр улсын өмнө нийтийн маш том сэдэв болж байна. Монгол Улсын уламжлалт нүүдлийн мал аж ахуйн тогтолцоонд нүүдлийн бэлчээрийг ашиглах хэмжээ, хүрээ тодорхой бус, олон малчин өрх хотоос зайдуу газар төвлөрч, малын бэлчээр буюу усны ундаргын харьцангуй сайн нөхцөлтэй, гол, нуур эргэн тойронд буй бэлчээрийг ашиглаж байсан нь улиран өнгөрч, цөлжиж ор мөр л үлджээ. Зам тээврийн нөхцөл муугаас мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг алс холоос зах зээлд аваачиж борлуулахад маш их төвөгтэй, илүү зардал гардаг; Хятад улс бол тал нутгийн малын бэлчээрийг өрхөд хариуцуулах бодлого явуулснаар нутгийн хил хязгаар доторхи их хэмжээний газрыг малчид бэлчээрээ бий болгох, хамгаалах, хөрөнгө оруулах, хамтран ашиглах зэргээр өөрийн дураар хөдөлгөдөг болсон. Ялангуяа эдгээр бэлчээр талбай бага бол усны нөөцөөр харьцангуй сайн (жишээлбэл Ордос хотын мал аж ахуйтай хошуу) газар, малчин өрх өөрийн хариуцлагын системийн хүрээнд малын бэлчээрийг хүрээлж, хавар, зун, намрын бэлчээр болгон хуваарилахаас гадна тариалангийн газар болгон ашиглаж байна. Эдгээр сайхан туршлага нь Монгол Улсын одоогийн малын бэлчээрийг удирдан зохион байгуулах тогтолцоонд хэрэг болох ач тустай, хэрэгжүүлмээр сайхан арга хэмжээ юм.

Монгол Улс хүний нөөцөөр маш баян, арвин их баялаг нөөцтэй. Эдгээр нөөц баялагаа тууштай зөв ашиглаж чадвал Монголын ард түмэн өнө урт хугацаанд хүртэх бололцоотой. Монголын цаг агаарын нөхцөл эрс ширүүн боловч эндхийн байгаль экологийн маш тааламжтай нөхцөлд зохицсон амьтан, ургамлын нөөцтэй, эдгээр нөөц баялаг тухайн бүс нутгийн экологийг хамгаалах явдал бол дэлхийн байгаль экологийг хамгаалан хөгжүүлэхэд маш их ач холбогдолтой юмаа. Гэвч эндхийн

олон амьтан, ургамлын төрөл зүйл түргэн хугацаанд багасан цөөрч, зарим төрөл нэг бус удаа устаж байна. Монголын амьтан, ургамал, экологийн системийг хамгаалах нь дэлхийн амьд организмын үндсийг хадгалахтай маш нягт холбоотой, иймээс олон улсын нийгэмлэгээс дээд зэргийн ач холбогдолтой тооцож, холбогдох тусламжийг авах хэрэгтэй.

Монгол Улсын аж үйлдвэрийн үндэс суурь нь хээр талын нүүдлийн мал аж ахуй боловч ирээдүй нь тодорхой бус бүрхэг байна, иймээс давын өмнө эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэн ашиглах явдлыг чангатгах, экологийн эдийн засгийн аюулгүй байдлын далд заналхийллийг илрүүлэх хэрэгтэй. Эдийн засгийн бодлогын гол төв нь хүн амын орлогыг нэмэгдүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, нөөц баялгын ашиглалтыг чангатган нэмэгдүүлэх, ялангуяа байгалийн нөөцийг ашигласны дараах нөхөн сэргээлтийг зайлшгүй нэмэгдүүлэн чангатгах хэрэгтэй байна.

Монголын ард түмний нөөц баялгийн төвшин, эдийн засгийг хөгжүүлэх бодлого, байгаль экологийн нэгдсэн бодлого, газар, бэлчээр, усны нөөц, цаг уур, ой модны нөөцийг зөв ашиглах гэх мэт тогтолцоо бодлогыг оновчтой зөв явуулан, хэрэгжүүлж чадваас Монголын ард түмэн нөөц баялгаа өнө мөнхөд хэрэглээд зогсохгүй, мөн түүнчлэн дэлхийн байгаль экологийг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах болно, бидний алдааг бүү давтаасай гэсэн үнэтэй саналыг Өвөр Монголын эрдэмтэн судлаачид энэхүү номонд тусгажээ.

Өвөр Монголын эрдэмтдийн бичсэн судалгааны энэхүү хамтын бүтээл хэрэв монгол хэлээр хэвлэгдэх аваас манай эрдэмтэн судлаачид, хөдөө аж ахуй, мал аж ахуйн мэргэжилтэн, малчин ардад нэн тустай, ач холбогдолтой хэрэг болох буй заа.